

ТАНИЛЦУУЛГА

2023.04.18

хот

Улаанбаатар

“Олон нийтийн байцаагчийн
ажиллах нийтлэг журам”-ын
төслийн талаар

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэгт “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор төрийн бус байгууллага болон баг, хорооны Засаг даргын саналыг үндэслэн сум, дүүргийн Засаг дарга харьяа нутаг дэвсгэртээ эргүүлийн үүрэг гүйцэтгэх олон нийтийн байцаагчийг томилон ажиллуулна.”, мөн зүйлийн 40.2 дахь хэсэгт “Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хүн амын нягтрал, гэмт хэрэг, зөрчлийн гаралтын түвшинг харгалзан харьяа нутаг дэвсгэртээ ажиллах олон нийтийн байцаагчийн тоог тогтооно.”, мөн 40.3 дахь хэсэгт “Цагдаагийн байгууллага олон нийтийн байцаагчийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах бөгөөд иргэд, хуулийн этгээд, олон нийтийн байцаагчид энэ хуульд заасан үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай дэмжлэг, туслалцааг үзүүлэх үүрэгтэй.”, мөн 40.4 дэх хэсэгт “Олон нийтийн байцаагчид энэ хуулийн 34.3-т заасан журмын дагуу урамшуулал олгоно.”, мөн 40.6 дахь хэсэгт “Олон нийтийн байцаагч гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх эрхээ хэрэгжүүлэхдээ энэ хуулийн 39 дүгээр зүйлд заасан баталгаагаар хангагдана.”, мөн 40.7 дахь хэсэгт “Олон нийтийн байцаагчийн ажиллах нийтлэг журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэж заасан.

Иймд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд нийтийн хэв журмыг сахиулах зорилгоор олон нийтийн байцаагчийн ажиллах “Нийтлэг журам батлах тухай” Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаал, журмын төслийг боловсрууллаа.

Журмын төсөлд олон нийтийн байцаагчийн удирдлага, зохион байгуулалт, тавигдах шаардлага болон чиг үүргээ хэрэгжүүлэх нийтлэг харилцааг зохицуулахаар 7 хэсэгтэйгээр боловсрууллаа.

Танилцуулж буй төслийн хувьд дээр дурдсан хуулийн хүрээнд торгох эрхгүй зөвхөн шаардлага тавих, мэдээлэх, санал гаргах, эрх бүхий албан тушаалтанд мэдэгдэх зохицуулалтайгаар үйл ажиллагааны хэлбэрийг тодорхойлов.

Олон нийтийн байцаагчтай холбоотой урамшуулах зардлыг Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4 дэх хэсэгт “Олон нийтийн байцаагчид энэ хуулийн 34.3-т заасан журмын дагуу урамшуулал олгоно.” мөн хуулийн 34 дүгээр зүйлийн 34.3 дахь хэрэгт “Энэ хуулийн 34.1, 34.2-т заасны дагуу урамшуулах хэлбэр, журмыг хууль зүйн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.” гэж заасны дагуу Хууль, зүй дотоод хэргийн сайдын тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг “Гэмт

хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцсон иргэд, байгууллагыг урамшуулах журам”-ын төслийг боловсруулж Сангийн яаманд хүргүүлсэн байна.

“Олон нийтийн байцаагчийн ажиллах нийтлэг журам”-ын төсөл батлагдсанаар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд харьяа нутаг дэвсгэртээ эргүүлийн үүрэг гүйцэтгэх олон нийтийн байцаагчийн ажиллах боломж бүрдэж, иргэд олон нийтийн оролцоо нэмэгдэж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын чанар, үр дүн, хүртээмж дээшлэх **ач холбогдолтой гэж үзлээ.**

-оОо-

